

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.02.07-2022.02.11/

2022.02.11

Дархан хот

№	Ажлын чиглэл	Гүйцэтгэлийн үр дүн
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилгын чиглэл	<p>Засгийн газрын 212-р тогтоолын дагуу 2 гадна цахилгааны шугамын ажилд ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Дархан сум, 13-р баг, “Эрд хул” ХХК-ний ШТС агуулах - Дархан сум, 13-р баг, “Бурхант эко асфальт” ХХК-ний автозамын бетон асфальтны үйлдвэр <p>Засгийн газрын 2009 оны 157-р тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн Аймгийн ОБГ азарт хүргүүлсэн.</p>
2	Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр	<p>Дархан-Уул аймагт Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа 28 ААНБ-уудаас Барилга, Хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019.12.18-ны өдрийн 206,А/184 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2021 оны мэдээг хүлээн авсан. 2022 оны 2 сарын 08-ны байдлаар 23 байгууллага мэдээ ирүүлсэн байна. Гялалзах гэрэл ХХК, Их торгоны зам ХХК, Мэжик ньу ворлд ХХК-ууд мэдээ ирүүлээгүй болно. Харин Гантиг өргөө ХХК, Чуань Мон арматур ХХК-иуд 2021 онд үйлдвэрлэл явуулаагүй тухай албан тоот ирүүлсэн. Мэдээг нэгтгэн 2022.02.09-ний 67 албан тоотоор Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоонд хүргүүлээ.</p>
3	Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	<p>2022 онд хийгдэхээр төлөвлөгдөж байгаа Залуус хороолол 1, Залуус хороолол 2-ын инженерийн шугам сүлжээний трассын зураг, материалын түүврийг гаргаж ХОХБТХ-т хүргүүлсэн. Хабитат чиглэлийн инженерийн шугам сүлжээний 2 ээлжийн ажлын УДДТ-ийн байршилзудыг тодорхойлох, шугамын трассыг ерөнхий зураг төслийг гүйцэтгэсэн.</p>
4	Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлал	<ol style="list-style-type: none"> 1. Urban.gov.mn цахим системд 15 барилгын мэдээллийг ArcGis программаас мэдээллийг авч оруулсан. 2. E-gazar.gov.mn сайтад иргэдэд үйлчлэх хуваарийн дагуу цахим бүртгэл дээр ажилласан.
Газрын удирдлагын хэлтэс		
1	Суурь судалгаа, газрын мониторинг	<p>Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан болон дүгнэлтийг хянаж, Газрын мониторингийн цахим системээр 4 тайлан баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх 6 иргэнд хянан баталгаа хийлгэх тухай мэдэгдэх хуудсыг хэвлэж өгсөн.</p>
2	Геодези, зураг зүйн чиглэл	<p>Хаягийн зургийн дагуу 4 иргэн, 1 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон. Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц, гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн 4 иргэн, 0 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан. Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн 3 иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн. Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шалгагдаж байгаа гэмт хэргийн бүртгэлийн 129 дугаартай гомдол мэдээлэлд дурдагдсан газрын байршлыг харуулсан зургийг гаргаж хүргүүлсэн. Уг газар нь Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутаг дэвсгэрт байрлаж байгаа нь өгөгдсөн солбицол болон хилийн цэсийн зургаар баталгаажиг байна. Шуудан хүргэлтийн ажилчид зориулан Дархан сумын 15 дугаар багийн 1-10-р хэсгийн хаягийн зургийг авах хүсэлтийг ирүүлсэн “Монгол шуудан” ХХК-ны хүсэлтийн дагуу 1-10-р хэсгийн хаягийн 13 ширхэг зургийг А4 форматаар / шинэ,</p>

		хуучин / хэвлэн хүргүүлсэн.
2	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн чиглэл	Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, хуутгээдийн нийт 3 албан бичгийн лавлагааг мэдээллийн сан болон газар өмчлөх захирамжаас шүүж хариуг хүргүүлсэн. 2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг www.egazar.gov.mn цахим хуудаснаас хэрхэн гарах боломжтойг мэдээлэл өгсөн. 2022-01-05 - ны өдөр Эцэг эхийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Эцэг эхийн зөвлөл нь албан хаагчдын хүүхдийн төрсөн өдрийн судалгааг авч ажилласан. Эцэг эхийн зөвлөл нь хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрсөн тухай албан хаагчдаар гарын үсэг зуруулав.
3	Газрын төлбөр, татвар, үнэлгээ	2022 оны газрын төлбөрийн ногдол үүсгэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Улсын хэмжээнд газрын төлбөрийн ногдуулалтыг татварын системд илгээхэд Газрын кадастрын мэдээллийн систем болон Татварын удирдлагын нэгдсэн /татварын тайлант хугацаатай давхцах/ системүүдийн ачаалал өндөр байгаа тул уг ажил удаашралтай байна. Аймгийн хэмжээнд 8300 гаруй гэрээ /Дархан 4600, Орхон 729, Хонгор 2710, Шарын гол 290/-нд ногдол, нэхэмжлэл үүсгэх ажил үргэлжилж байна.
Захиргаа удирдлага		
1	Хүний нөөц, хууль эрх зүйн чиглэл	Шүүхийн мэдээлэл: Дархан Ти Ви ХХК-ний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 14:00 цагт болж, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ГХБХБГ-аас Б.Золбаясах оролцсон, анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Сургалт: ТАЗөвлөлөөс 7 хоног бүрийн Пүрэв гаригт 10:00 цагт зохион байгуулагдсан “ Монгол орны хөгжлийн хэтийн төлөв” сэдвээр Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, ШУДоктор Ч.Хурц гуай илтгэсэн сургалтад тус байгууллагаас 2 албан хаагч цахим хамрагдсан. ГЗБГЗЗГ-аас зохион байгуулагдаж байгаа 2022/02/11-ний өдрийн “Хот байгуулалтын цахим систем”-ийн сургалтад Барилга, хот байгуулалтын хэлтэсд шинээр томилогдсон М.Дарьсүрэн нь хамрагдаж байна. Мөн “Ланд Менежер”-ын программын эрх олгох сургалтад Хонгор сумын газрын даамал Б.Гантуяа хамрагдаж байна. Хүний нөөц: “2022 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулхаар боловрсруулж байна. Байгууллагын 22 албан хаагчид 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээгээ 2022/02/09-ны өдөр газрын даргаар батлуулсан. 2022 оны албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг газрын даргаар батлуулсан. ЭБАТ: 4 албан хаагчийн ХАСХОМ-ын мэдүүлгийг бөглүүлж, баталгаажилтыг хийж хуулийн хугацаанд гаргаж ажилласан. Үүрэг даалгавар: Аймгийн Засаг дарга, орлогч, ЗДТГ-ын дарга нараас төрийн байгууллагуудад өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг боловсруулж байна.
2	Мэдээллийн технологи, нярав	Мэдээлэл: 1. 70376471 нээлттэй утсаар 14 иргэний асуултанд хариулт өгөв. 2. Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Facebook хуудсанд иргэнээс асуусан 4 асуултанд хариулсан. Мэдээлэл технологийн чиглэлээр: 1. Суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтний компьютерт хэвлэгчийг таниулж өгөв. Нярав: 1. 20 ширхэг Нэгж талбарын хувийн хэргийн хавтас нугалж, мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. 2. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 6 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгов. 3. Шаардах хуудсаар 3 төрлийн 3 ширхэг бараа материал олгов. Архив, бичиг хэрэг:

		<ol style="list-style-type: none">1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл 1 ширхэг, ААНБ-уудаас ирсэн албан бичиг 17 ширхэгийг албан хэрэг хөтлөлтийн Able системд бүртгэж байгууллагын даргаар цохуулан мэргэжилтнүүдэд тарааж өгөв.2. Байгууллагын мэргэжилтнүүдийн шийдвэрлэсэн албан бичиг 8 ширхэгийг албан хэрэг хөтлөлтийн Able системд шийдвэрлэгдсэнээр бүртгэн хааж, хураав.3. Байгууллагаас бусад байгууллага болон иргэдэд илгээж буй албан бичиг 7 ширхэгийг бланкан дээр буулгаж, илгээв.4. Байгууллагын даргын тушаал 2 ширхэгийг бланкан дээр буулгав.5. Архиваас 5 ширхэг материал мэргэжилтнүүдэд гаргаж өгөөд, хэрэглэсний дараа 4 ширхэгийг хураав.
--	--	--

Тайлан боловсруулсан:

Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Золбаясах

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Г.Нямдорж